

UCS.....2023

## ИЖ БҮРЭН ГУДАМЖ



Ногоон байгууламж бүхий гудамжны төлөвлөлт хийх удирдамж

Улаанбаатар хот  
2023 он



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

ИЖ БҮРЭН ГУДАМЖ  
Ногоон байгууламж бүхий гудамж

## ГАРЧИГ

ЗОРИЛГО.....	5
ХАМРАХ ХҮРЭЭ.....	5
НОРМАТИВ ЭШЛЭЛ .....	5
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР .....	5
НОГООН БАЙГУУЛАМЖ БҮХИЙ ГУДАМЖНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА .....	6
ТӨРӨЛ АНГИЛАЛ.....	6
ЦЭЦЭРЛЭГТ ГУДАМЖ БУЮУ БУЛЬВАР .....	6
ЦУВАА ЦЭЦЭРЛЭГ БУЮУ АЛЛЕЙ .....	8
ЦЭЦЭРЛЭГТ ГУДАМЖ БУЮУ БУЛЬВАР ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА .....	9
НОГООН БАЙГУУЛАМЖААС БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ ХҮРТЭЛХ ЗАЙ ХЭМЖЭЭ .....	11
НОГООН БАЙГУУЛАМЖ БҮХИЙ ГУДАМЖИНД ЗОХИСТОЙ ЧИМЭГЛЭЛИЙН МОДЛОГ УРГАМЛУУД .....	12
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН УСАЛГАА БА АРЧИЛГАА.....	13
УСАЛГАА .....	13
ТАЙРАЛТ БА ХЭЛБЭРЖҮҮЛЭЛТ .....	13
НОГООН БАЙГУУЛАМЖ БҮХИЙ ГУДАМЖНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ .....	14

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Дундын Бульвер .....	7
Зураг 2. Бульвар гудамж.....	7
Зураг 3. Олон замт бульвар.....	8
Зураг 4.Цуваа цэцэрлэг буюу Аллей.....	8
Зураг 5. Тохиромжтой зай хэмжээ.....	9
Зураг 6. Ургамлан хашлага.....	9
Зураг 7. Хоёр зорчих хэсэгтэй дөрвөн эгнээтэй автозам .....	10
Зураг 8. Хоёр зорчих хэсэгтэй зургаан эгнээтэй автозам .....	10
Зураг 9. Цэцэрлэгт гудамжны өргөн ба явган замын харьцаа .....	11
Зураг 10. Бороожуулах усалгааны системийн жишээ .....	13
Зураг 11. Шилмүүлс тодны хэлбэржүүлэлтийн жишээ .....	14

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ойр ногоон байгууламж төлөвлөх зай хэмжээ.....	11
Хүснэгт 2. Ногоог байгууламж бүхий гудамжинд тохиромжтой модлог ургамал .....	12
Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлт .....	14

## ИЖ БҮРЭН ГУДАМЖ

---

### Ногоон байгууламж бүхий гудамж төлөвлөх түүнд хэрэглэгдэх мод, бут, сөөг сонгох ерөнхий шаардлага

---

#### ЗОРИЛГО

Энэхүү баримт бичгийн зорилго нь ногоон байгууламж бүхий гудамжийг хэрхэн төлөвлөх түүнд ашиглагдах мод, бут, сөөгийг сонгох үйл ажиллагаанд удирдамж өгч иргэдийг эрүүл тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

#### ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү баримт бичгийг цэцэрлэгт гудамж бүхий ногоон байгууламж төсөллөх, ландшафт архитектурын зураг төсөл боловсруулах, гүйцэтгэхэд хэрэглэнэ.

#### НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү баримт бичигт Монгол улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дараах бодлогын болон норм, нормативын баримт бичгүүдэд суурилсан бөгөөд тухайн баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн албан ёсны эх хэвлэлийг баримтална.

- БНБД 3.01.03.88 – Тохижилтын ажил;
- БНБД 32-01-04 – Хот суурины гудамж, зам төлөвлөлт;
- БНБД 81-59-05 – Тохижилт, бусад ажил;
- MNS – 6258-1:2011 – Суулгацын нүх бэлдэх;
- MNS – 6139:2010 – Шилмүүст төрлийн модны суулгац, техникийн шаардлага;
- MNS – 5973:2009 – Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай хэмжээ;
- UCS 0801A:2020 – Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн төлөвлөлт;
- UCS 0803A:2020 – Мод, таримал ургамлын төрөл зүйлийн лавлах;
- UCS 0804A:2020 – Ногоон байгууламжийн арчилалт, усалгааны менежмент;

#### НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

**Ландшафт** – гэж тухайн газар нутгийн ургамлын бүрхэвч, гадаргуугийн тогтцоор илэрхийлэгдэх байгалийн дүр төрх;

**Авто замын дагуух ногоон байгууламж** – гэж дуу чимээ бууруулах, агаарыг цэвэршүүлэх, хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор замын хоёр тал болон тусгаарлах бүсэд мод, цэцэг, зүлэг тарьсан газрыг хэлнэ;

**Ногоон байгууламж** – гэж иргэдийн аялж амрах, орчны үзэмжийг нэмэгдүүлэх, хамгаалах зэрэг төрөл бүрийн ногоон ургамлуудыг цогц;

**Цэцэрлэгт гудамж буюу бульвар** – гэж явган хүний хөдөлгөөнийг цэгцлэх зорилгоор өргөн гудамжны төв хэсэг, гол мөрөн нуурын захаар 1-2 эгнээгээр мод цувуулан тарьж байгуулсан байгууламж;

**Цуваа цэцэрлэг буюу аллея** – гэж Хот суурин газрын замыг явган хүний замаас тусгаарлах зорилгоор байшин барилгын нүүр, ханыг чимэглэж, хөшиг болгон ашиглах үүднээс замын хоёр хажуугаар мод сөөг цувруулан тарьж байгуулсан байгууламж;

**Бульвар гудамж** – гэж Хөндлөн огтлол нь энгийн гудамжтай ижил боловч арай илүү өргөн бөгөөд 2 талаараа ногоон зурвасаар тусгаарлагдсан цэцэрлэгт гудамж;

**Дундын бульвар** – гэж Энэ нь бусад бульвар цэцэрлэгээс 2 автозамаар хашигдсан явган хүн амарч зугаалах боломжтой ногоон байгууламжтай;

**Олон замт бульвар** – гэж Энэ төрлийн бульвар нь ногоон зурвасаар тусгаарлагдсан олон эгнээ автозамтай цэцэрлэгт гудамж;

## НОГООН БАЙГУУЛАМЖ БҮХИЙ ГУДАМЖНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Ногоон байгууламж бүхий гудамжны гол ач холбогдол нь хүрээлэн буй орчны өнгө үзэмжийг дээшлүүлэх, иргэдийн түр амарч суух, эрүүл аюулгүй орчинг бүрдүүдэх үүрэгтэй.

- Хотын ногоон байгууламжийн системийн төлөвлөлтийн хугацааг хотын ерөнхий төлөвлөлттэй адил хийж, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлно.
- Ногоон байгууламжийг хот суурин газрын оршин суугчдын тоо, түүний шилжилт хөдөлгөөн, цаашдын өсөлтийн хандлага, гудамж замын хөдөлгөөн зэрэг олон хүчин зүйлийг харгалзан харилцан адилгүй хэмжээ ангиллаар тодорхой төлөвлөгөөний дагуу байгуулна.
- Байгалийн ландшафтын онцлог ба уул, усны экологийн систем, түүний тэнцвэрт байдал болон тухай байршлын шинж чанар дүр төрхийг алдагдуулахааргүй төлөвлөнө.
- Цэцэрлэгт саад, цэцэрлэгт гудамж, цуваа цэцэрлэг гэх мэт ногоон байгууламжийг байгаль орчны тогтоц хэв маягийн дагуу геометрийн төрөл бүрийн хэлбэртэйгээр байгуулж болно.
- Ногоон байгууламжийн мод бут сөөгийг байгаль цаг уур, хөрсний шинж чанар, ямар зориулалтаар байгуулах болсон шалтгааныг харгалзан үзэж төлөвлөлтөд сонгон хэрэглэнэ.
- Мод, бут, сөөгийг титмийн хэлбэр, холтосны өнгө, цэцэглэх хугацаагаар нь хослуулан төлөвлөнө.
- Ногоон байгууламжийн нэгж элементүүд нь ногоон байгууламжийн ангилал бүрд хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж тааламжит орчныг бий болгох, тус тусын үүрэг зорилготой байна.
- Ногоон байгууламжийн үндсэн элементийн архитектурын бага элементүүдтэй хослуулан төлөвлөнө.
- Ногоон байгууламж дахь архитектурын бага хэлбэрүүд нийт талбайн 2%-аас хэтрэхгүй байх.
- Цэцэрлэгт гудамжийг 2 ба түүнээс дээш орц, гарцтайгаар төлөвлөнө.
- Усалгаа ба арчилалтын талаар тогтмол тэмдэглэл хөтлөн баримтжуулан хадгална.

## ТӨРӨЛ АНГИЛАЛ

Нийтийн зориулалттай ногоон байгууламж болох цэцэрлэгт гудамж нь түүнийг дамжин өнгөрөх иргэдийн ая тух, орчны аюулгүй байдлыг хангах, хүрээлэн буй орчны өнгө үзэмжийг дээшлүүлэх зорилготой. Ногоон байгууламж бүхий гудамжийг дараах 2 төрөлд ангилан үзнэ.

Үүнд:

- Цэцэрлэгт гудамж буюу Бульвар
- Цуваа цэцэрлэг буюу Аллей


## ЦЭЦЭРЛЭГТ ГУДАМЖ БУЮУ БУЛЬВАР

Хоёр талаараа автозамаар хязгаарлагдсан өргөн (18-50м) чөлөө юм. Авто зам дагуу тохижуулсан нийтийн эзэмшлийн талбай, явган хүний дамжин өнгөрөх хөдөлгөөн, богино хугацааны амралтад зориулагдсан. Энэхүү өргөн чөлөө нь явган хүний болон замын байгууламжийн салшгүй хэсэг юм. Бульвар цэцэрлэгийг 3 хэлбэрт ангилдаг.

1. Center median boulevard – Дундын бульвар
2. Boulevard street – Бульвар гудамж
3. Multi-way boulevard – Олон замт бульвар

Төв замтай нэг дор төлөвлөх тохиолдолд түүний таагүй нөлөөг бага мэдрүүлэхийн тулд салхин талд нь 2-4 эгнээ мод, бутны суулгацаар хамгаалалт хийдэг. Амралтын жижиг талбайг зарим хэсгийг нартай, зарим хэсгийг сүүдэртэй байхаар төлөвлөнө. 1 га хүртэлх жижиг талбайг 50-65% -г ногоон байгууламж эзлэхээр зураг төсөлд тусгана. Үүнээс том талбайтай байх тохиолдолд 75%-г ургамалжуулахад зохистой. Бульвар цэцэрлэг байгуулах газрын хэмжээ өргөн биш тохиолдолд гол замыг 4-6 м-н өргөнтэй, түүнтэй зэрэгцүүлэн нарийвтар зам, сууж амрах талбайг хамт төлөвлөнө.

*Зураг 1. Дундын Бульвер*



*Зураг 2. Бульвар гудамж*



Зураг 3. Олон замт бульвар



Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй уялдаатай байх шаардлагатай бөгөөд дамжин өнгөрөгсдийн аюулгүй байдлыг хангаж зам тээврийн ослыг 7% бууруулах боломжтой.

### ЦУВАА ЦЭЦЭРЛЭГ БУЮУ АЛЛЕЙ

Хот суурин газрын автозамыг явган хүний замаас тусгаарлах зорилгоор байшин барилгын нүүр, ханыг чимэглэж, хөшиг болгон ашиглах үүднээс замын хоёр хажуугаар мод сөөг цувруулан тарьж цэцэрлэгжүүлэхийг хэлнэ.

Аллейд модыг нэг эгнээгээр хоорондоо 4-8 метр зайтай суулгана. Нэг эгнээ цуваа цэцэрлэгт шинэс, нарс, улиас, хайлаас зэрэг мод, өрөл, долоолгоно, шар хуайс хайлаас, нохойн хошуу зэрэг сөөгийг суулгахад тохиромжтой.

Зураг 4.Цуваа цэцэрлэг буюу Аллей





## ЦЭЦЭРЛЭГТ ГУДАМЖ БУЮУ БУЛЬВАР ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА


- Бульварыг явган хүний хөдөлгөөнийг цэгцлэх зорилгоор өргөн гудамжны төв хэсэг, гол мөрөн нуурын захаар 1-2 эгнээгээр мод цувуулан тарьж байгуулна.
- Хөдөлгөөнийг зохицуулсан цуваа цэцэрлэг нь өргөн гудамжны дундуур гаргасан явган хүний замаас 3-5 метр зайтай, хоёр тал нь нарийн зурвасаар зүлэгжүүлнэ.
- Модыг эгнээ хооронд 6 метр, мод хооронд 5-6 метр зайтайгаар байгуулна.

Зураг 5. Тохиромжтой зай хэмжээ



- Цэцэрлэгт гудамжны захаар нь бут сөөгийг 25-30 см зайтай суулган ургамлан хашлага хийж өгч болно. Ургамлан хашлаганы өндөр тээврийн хэрэгсэл жолоодож буй жолоочийн үзэгдэх орчныг хязгаарлахааргүй 70-100см өндөртэй байхаар тооцно.


Зураг 6. Ургамлан хашлага



- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.
- Замын хөдөлгөөний эрчмээс хамааран дараах байдлаар ангилна. Үүнд:
  1. Хоёр зорчих хэсэг дөрвөн эгнээтэй замын голд байрлах цэцэрлэгт гудамж;  
*Жолоочийн үзэгдэх орчинг хязгаарлахгүйн тул автозамын голын ногоон байгууламжийн мод, бутны ёроолоос дээш 120см дахь мөчрийг тайрч танана./*


Зураг 7. Хоёр зорчих хэсэгтэй дөрвөн эгнээтэй автозам

Жолоочийн үзэгдэх орчинг хязгаарлахгүйн тулд модны ёроолоос дээш 120см дэхь мөчирийг тайрч таналт хийнэ.




2. Хоёр зорчих хэсэг зургаан эгнээтэй замын голд байрлах цэцэрлэгт гудамж;

Зураг 8. Хоёр зорчих хэсэгтэй зургаан эгнээтэй автозам



- Суулгацын хэмжээг 100-200 мод, 1200 орчим бут сөөг 1 га-д байхаар тооцно.
- Бульвар цэцэрлэг доторх мод, бутны өндөр 6м-с ихгүй байна.
- 25м-с бага өргөнтэй бульварын явган замын зорчих өргөн 3-6м, 25м-с дээш өргөнтэй бульварт 1-с олон эгнээ явган замыг 1,5м-с их байхаар төлөвлөнө. /Зураг 9/
- Уулзвар, явганы хүний гарц, зогс тэмдэглэгээнээс хамгийн багадаа 1м-ийн наана дуусгавар ногоон байгууламжийн мод бут сөөгийг төлөвлөнө.

Зураг 9. Цэцэрлэгт гудамжны өргөн ба явган замын харьцаа



- Урт болон өргөний харьцаа хамгийн багадаа 3:1 байна.
- Бульвар цэцэрлэгийн орц гарц хоорондоо 150-300м зайтай байна.

### НОГООН БАЙГУУЛАМЖААС БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ ХҮРТЭЛХ ЗАЙ ХЭМЖЭЭ

Барилга, инженерийн байгууламж, зам харгуйн ойролцоох ногоон байгууламжийг төлөвлөх, зураг төсөл боловсруулах, цэцэрлэгжүүлэхэд MNS 5973:2009 –д заасан стандартын шаардлагыг хангасан байна.

Хүснэгт 1. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ойр ногоон байгууламж төлөвлөх зай хэмжээ

№	Барилга байгууламж, зам, инженерийн шугам сүлжээ	Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний тэнхлэг	
		Шилмүүст болон навчит модны гувар ишний тэнхлэг хүртэл, м	Бут, сөөг, сөөгөнцрийн гол хүртэл, м
1	Явган зам, цэцэрлэгжсэн замын хашлаганы захаас	1.0	0.7
2	Авто машин, троллейбусны замын зах, хашлаганаас	2.0	1.0
3	Гудамжны зорчих хэсгийн ирмэг, замын хажуугийн хашлагаас	2.0	1.0
4	Газар дээрх болон доорх шугам сүлжээнээс. Үүнд:		
	а/ дулаан дамжуулах шугам	3.0	3.0
	б/ цэвэр, бохир усны шугам	3.0	3.0
	в/ цахилгаан дамжуулах утас	2.5	2.0
	г/троллейбусны болон гэрлийн шон	5.0	2.0
5	Таримал мод, ургамлын:		

a/ ургамал хоорондын зай	3.0-4.0	0.7-1.5
б /эгнээ хоорондын зай	2.5-4.0	1.0-1.5
в/ сөөлжлөн суулгасан эгнээ хоорондын зай	2.5-4.0	1.0-1.5

## НОГООН БАЙГУУЛАМЖ БҮХИЙ ГУДАМЖИНД ЗОХИСТОЙ ЧИМЭГЛЭЛИЙН МОДЛОГ УРГАМЛУУД

Хотын ногоон байгууламжийг төлөвлөхдөө түүний талбайн хэмжээнээс гадна түүнийг бүрдүүлэх ургамал, бут сөөг, модны зүйлийн бүрдлийг анхаарч зохистой сонголт хийх шаардлагатай. Жишээлбэл: Туулайн бөөр, дал мод, хар улиас нь хар тугалгыг сайн шингээдэг байхад улиангар, гацуур, агч мод нь нүүрстөрөгчийн дутуу ислийн /CO/ сайн шингээх ба улиас, бургас, агч мод нь агаар дах тоосжилтыг багасгадаг онцлогтой.

Манай орын нөхцөлд бульвар байгуулахдаа шинэс, гацуур, нарс, хайлаас, улиас, хус, шар хуайс, хайлаас, нохойн хошуу, сөөгөн боролзгоно, тэхийн шээг зэрэг мод, сөөгийг хэрэглэх нь илүү тохиромжтой.

Хүснэгт 2. Ногоог байгууламж бүхий гудамжинд тохиромжтой модлог ургамал

№	Ургамлын нэр	Цэцгийн өнгө үнэрээр чимэглэдэг	Навчны өнгөөр чимэглэдэг	Холтосны өнгөөр чимэглэдэг	Үр жимсээр чимэглэдэг	Ганц нэгээр тарих	Таримал хашлага хэлбэрээр тарих	Эмжээрлэж тарих	Зөллөсөн хэлбэрээр
1	Гацуур					+			+
2	Улиас		+	+		+			+
3	Нарс			+		+			+
4	Шинэс					+			+
5	Монос	+				+			
6	Хус			+					
7	Шар хуайс			+			+		
8	Нохойн хошуу		+		+		+		
9	Өрөл				+				
10	Долоогоно		+		+				
11	Голт бор	+							
12	Гүйлс	+							
13	Тэхийн шээг							+	
14	Боролзгоно							+	
15	Хайлаас						+		
16	Цагаан бургас		+						

## НОГООН БАЙГУУЛАМЖИЙН УСАЛГАА БА АРЧИЛГАА

Усалгааны хэмжээ нь тухайн модны төрөл зүйл , хэмжээ, нас, хөрсний байдал, нар болон сүүдэр талд байгаа эсэх, салхин далд байгаа юу зэргээс хамаарна. Ногоон байгууламжийн усалгааг тогтмол хугацаанд шаардлагатай усыг нь тогтвортой өгөх ёстой. Модыг байнга тогтвортой усалж байснаар үндэсний систем хялгасан сахлаг байдлаар бэхжиж усны шингээлтийг өөртөө татах чадвар нь сайжирдаг. Хөрсний чийг нь бүрэн чийг багтаамжийн 60 % байхад мод хамгийн сайн ургадаг. Хөрсөн дэх чийгийн дутагдал нь ургамлын эрдэс тэжээлийн хүртээмжийг бууруулдаг.

Хаврын улиралд үндэсний тогоог боломж гарах бүр цасаар байнга дүүргэж байх нь ургамалд тустай. Цас нь нарны элчээр хөрсөнд аажимдаа шингэдэг тул бусад усалгаанаас давуу талтай юм. Хавар хөрс бүрэн гэсэж амжаагүй үед цасны ус аажимдаа шингэх чадвар нь илүү сайн усалгаа болдог.

### УСАЛГАА

Ногоон байгууламжид дуслын усалгааны систем болон бороожуулах усалгааны систем хамгийн тохиромжтой. UCS 0804A:2020 “Ногоон байгууламжийн арчилалт, усалгааны менежмент” удирдамж арга зүйн баримт бичигт заасны дагуу төлөвлөж байгуулна.

Шүршиж услах нь шилмүүст мөнх ногоон мод болох нарс, гацуур, хуш, арц модонд онцгой хамааралтай. Шилмүүлс мод нь агаар дахь тоос тоосонцор, бохирдолын хамгийн ихээр шингээж авдаг учраас хавар дулаармагц шилмүүст модыг услахдаа мөчир салаанд чийг өгөхөөс гадна түүнд наалдсан хөө тортогыг арилгаж нарны гэрлийг шингээхэд тустай.

*Зураг 10. Бороожуулах усалгааны системийн жишээ*




### ТАЙРАЛТ БА ХЭЛБЭРЖҮҮЛЭЛТ

Хатсан ба цаашид ургах чадваргүй хэсгийг модноос тайрч авна. Энэ нь түүний ургалтанд сайн нөлөөтэй. Хатсан мөчир салаа нь модны үндэсний ачаалалд нөлөөлөх ба цаашид ургалтын байдалд саад болон бусад салаа мөчирд нөлөөлж модны чийгийг алдахад сөрөг нөлөө үзүүлдэг.

Ногоон байгууламжийн арчилгаанд мод сөөгийг тайрч танах замаар тухайн модны титэмд засал хийж титмийн өтгөрлийг зохицуулах, өндөр нам хэлбэрийг жигдрүүлэх, хатаж хуурайшсан, өвчилсөн болон гаж ургасан мөчир салааг цэвэрлэх ажлууд багтдаг.

Мод сөөгт намрын улиралд ургалт зогссон үед тайралт, таналт хэлбэржүүлэлт хийх нь үр дүн муутай тул дараа оны 2 дугаар сараас 4 дүгээр сарын эхэн үе хүртэл, мөн найлзуурын өсөлт зогсож, моджиж эхэлсэн 7 сарын дунд үеэс хойш хийх нь илүү тохиромжтой. Ногоон байгууламжийн тайралт, хэлбэржүүлэх, залуужуулах, цэвэрлэгээний огтлолыг UCS 0804A:2020 удирдамж арга зүйн баримт бичигт тусгасны дагуу хийж гүйцэтгэнэ.

Зураг 11. Шилмүүлс тодны хэлбэржүүлэлтийн жишээ



## НОГООН БАЙГУУЛАМЖ БҮХИЙ ГУДАМЖНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Дараах шалгуур үзүүлэлтийн хангаж байгаа бол **“Тийм”** хийгээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Ногоон байгууламж бүхий гудамжийг хот суурин газрын оршин суугчдын тоо, түүний шилжилт хөдөлгөөн, цаашдын өсөлтийн хандлага, гудамж замын хөдөлгөөнийг тооцон төлөвлөсөн эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Төлөвлөсөн байршлын онцлог байгаль цаг уур, хөрс болон биологийн шинж чанарыг харгалзан тохиромж ургамал сонгосон эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Цэцэрлэгт гудамжийг 2 ба түүнээс дээш орц, гарцтайгаар төлөвлөсөн эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Цэцэрлэгт гудамжинд модыг эгнээ хооронд 6 метр, мод хооронд 5-6 метр зайтай;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Цуваа цэцэрлэгт эгнээ хооронд 4-8м, мод хооронд 5-6м зайтай байхаар	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Цэцэрлэгт гудамжны захаар нь бут сөөгийг 25-30 см зайтай төлөвлөж гүйцэтгэсэн эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

7	Цэцэрлэгт гудамжинд суулгацын хэмжээг 100-200 мод, 1200 орчим бут сөөг 1 га-д байхаар тооцож төлөвлөсөн эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Тээврийн хэрэгсэл болон явган зорчигчийн үзэгдэх орчиныг хязгаарлахааргүй мод бут, сөөгийг тарьсан эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Инженерийн шугам сүлжээнээс мод, бут, сөөгийг стандартын дагуу төлөвлөж байгуулсан эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

*ТАЙЛБАР : Дээрх үнлдсэн шалгах үзүүлэлтүүдийн 60-75%-ээс дээш нөхцөлийг хангаж байвал “Тийм” гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай.*

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- БНБД 32-01-04 – Хот суурины гудамж, зам төлөвлөлт;
- БНБД 81-59-05 – Тохижилт, бусад ажил;
- MNS – 6258-1:2011 – Суулгацын нүх бэлдэх;
- MNS – 6139:2010 – Шилмүүст төрлийн модны суулгац, техникийн шаардлага;
- MNS – 5973:2009 – Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай хэмжээ;
- UCS 0801A:2020 – Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн төлөвлөлт;
- UCS 0803A:2020 – Мод, таримал ургамлын төрөл зүйлийн лавлах;
- UCS 0804A:2020 – Ногоон байгууламжийн арчилалт, усалгааны менежмент
- [http://www.soyolj.com/550/%D0%9C%D0%BE%D0%B4\\_%D1%82%D0%B0%D1%80%D0%B8%D1%85\\_%D0%B7%D0%B0%D0%B0%D0%B2%D0%B0%D1%80,%D0%B7%D3%A9%D0%B2%D3%A9%D0%BB%D0%B3%D3%A9%D3%A9.more](http://www.soyolj.com/550/%D0%9C%D0%BE%D0%B4_%D1%82%D0%B0%D1%80%D0%B8%D1%85_%D0%B7%D0%B0%D0%B0%D0%B2%D0%B0%D1%80,%D0%B7%D3%A9%D0%B2%D3%A9%D0%BB%D0%B3%D3%A9%D3%A9.more)